

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2021 оны 12 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Хот байгуулалт, хөгжлийн газрын Ёс зүйн зөвлөл нь газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/32, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/34 дугаартай тушаалаар байгуулагдан ажилласан.

Газрын даргын 2020 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан "Ёс зүйн дүрэм"-ийн баримтлан хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн мэдээллийн дагуу Ёс зүйн хорооны хурлыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 24 албан хаагчтай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэсэн. Хурлын шийдвэрийн дагуу 23 албан хаагчид сануулга өгч, уучлалт гуйх, 1 албан хаагчид Газрыг даргын тушаалаар хариуцлага тооцож ажилласан. /Авилгатай тэмцэх газрын 2021 оны 03/5547, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 02-02/1171, Нийслэлийн Архивын газрын 2020 оны 2/1075 дугаар бүхий албан бичиг, мөн газрын даргын өгсөн, Захиргааны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын шийдвэр зэргээс ирүүлсэн санал/

Мөн нийт албан хаагчдын нийтлэг гаргаж буй зөрчил, дутагдлыг арилгах, дахин давтахгүй үүднээс Зөвлөмж гаргаж газрын Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж, албан хаагчдад зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хурлын тэмдэглэлээр үүрэг болгов.

Газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1136 дугаартай албан бичгээр Нийслэлийн Сургалт, судалгааны төвийн "Албан бичгийн найруулга зүй", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, <https://erp.ulaanbaatar.mn/> систем ашиглалт, өргөдөл гомдлын систем" сэдэвт сургалтыг захиалга өгч эхний ээлжийн 40 албан хаагчийг 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 09-ний өдрүүдэд сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 03/4653 дугаартай албан бичиг, Газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр баталсан "Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хийх явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу 11 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд Ёс зүйн зөвлөлийн гишүүд 100% хяналт-шинжилгээний багт орж ажилласан бөгөөд албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлийн явцад зөрчил, дутагдал гаргасан 5 албан хаагчдад газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Б/86 дугаартай тушаалаар сануулах арга хэмжээ хүлээлгэсэн.

Төрийн албаны тухай хууль, Газрын дүрэм болон Ёс зүйн дүрэмд заасны дагуу төрийн албан хаагчийн ёс зүй, зарчмыг баримтлах, албан хаагчдыг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зэрэг хандлагыг төлөвшүүлж, хамт олноороо манлайлагч байх "Өөрчлөлтийг өөрөөсөө" уриан дор ажиллах 1 сарын аяны удирдамж батлуулан ажиллаж, 7 хоног бүр зөрчилгүй хэлтэс нэгж, албыг тодруулан, нийт албан хаагчдад мэдээлэл хүргүүлэн ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамж баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" журам, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр хурлын тэмдэглэл, Газрын даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн журам" зэрэг дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэхэд зорилготой сургалтын удирдамж батлуулан Нийслэлийн Прокурорын газарт хүсэлт гарган төрийн албан хаагчийн ёс зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан болно.

Тайлан хянасан:

Ёс зүйн зөвлөлийн дэд дарга

А.Одхүү

Тайлан бичсэн:

Нарийн бичгийн дарга

Н.Болор